

ДЭЛХИЙН ЦАГИЙН БҮС IX.15.1 - I

Цагийн бүсийг Лондон хотын Гринвичийн одон орны оргилоос эхлэн баруун (+), зүүн (-) тийш тоолдог бөгөөд нийт 24 цагийн бүсэд хуваагддаг. Монгол улс шинэ зураглалаар цагийн 6 болон 7 дугаар бүсэд оршдог. <https://www.timeanddate.com/time/map/> линкээр орж, хотуудын нэрээр цагийн бүсийг олох боломжтой.

Цагийн бүсийн зураг ашиглан дараах хотууд цагийн хэддүгээр бүсэд оршдог болохыг олж, тэмдэглэгээ ашиглан бичээрэй.

1а. Улаанбаатар хот Улаанбаатар (+7) гэж тэмдэглэнэ.	1б. Нур Султан хот
2а. Бээжин хот	2в. Сидней хот
3а. Москва хот.	3б. Токио хот.
4а. Варшав хот.	4б. Парис хот.
5а. Нью-Йорк.	5б. Денвер хот.
6а. Рио Де Жанейро хот.	6б. Алматы хот.
7а. Ховд аймаг.	7б. Баян – Өлгий аймаг.
8а. Дорнод аймаг.	8б. Сөүл хот.
9а. Лондон хот.	9б. Франкфурт хот.

Дасгалын дугаар	1а	1б	2а	2б	3а	3б	4а	4б	5а	5б	6а	6б	7а	7б	8а	8б	9а	9б	Нийт
Өөрийн үнэлгээ																			

ДЭЛХИЙН ЦАГИЙН БҮС IX.15.1 – II

Дэлхийн цагийн бүсийн зураг ашиглан дараах цагийн бүсэд орших хоёр хотын нэрийг бич.

<https://www.timeanddate.com/time/map>

1. (+1)

2. (+2)

3. (+3)

4. (+5)

5. (+6)

6. (-1)

7. (-2)

8. (-4)

9. (-5)


Дасгалын дугаар	1	2	3	4	5	6	7	8	9	Нийт
Өөрийн үнэлгээ										

Сурагчийн овог нэр

Эхэлсэн он сар өдөр цаг

ДЭЛХИЙН ЦАГИЙН БҮС IX.15.1 – III

Дэлхийн цагийн бүсийн зураг уншиж, 24 цагийн бүсэд хэрхэн хуваагддагийг газарзүйн мэдлэгээ ашиглан тайлбарлаж бичээрэй.



<https://www.timeanddate.com/time/map/>

Тайлбар.....
.....

Дууссан он сар өдөр цаг

ДЭЛХИЙН ЦАГИЙН БҮС IX.15.2 - I2021 оны 9 дүгээр сарын Олон улсын нислэгийн хуваарь. Эх сурвалж: www.gogo.mn

Өдөр	Нисэх, буух цаг (тухайн орон нутгийн цагаар)	Чиглэл
IX/1	10:40/14:50	УБ - Сөүл
IX/1	16:20/19:00	Сөүл - УБ
IX/4	10:00/14:50	УБ - Франкфурт
IX/4 – 5	16:20/08:30	Франкфурт - УБ
IX/6	11:40/17:15	УБ - Токио
IX/6	18:15/23:05	Токио – УБ
IX/9	11:30/13:30	УБ - Алматы
IX/9	15:00/20:40	Алматы – УБ
IX/10	05:45/14:10	Стамбул - УБ
IX/10 – 11	17:35/02:15	УБ – Стамбул
IX/13	11:30/13:30	УБ – Нур Султан
IX/13	15:00/20:40	Нур Султан - УБ

Хүснэгтээр өгсөн дээрх нислэгийн хуваарь ашиглан асуултад хариулаарай.

1а. УБ – Сөүл чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол. Бодолт: УБ хотын цагаар 10 цаг 40 минутад нисээд Сөүл хотын цагаар 14 цаг 50 минутад буусан гэж үзье. УБ (+7), Сөүл (+8) цагийн бүсэд оршдог буюу Сөүл 1 цагаар түрүүлж явдаг учир 14:50 – 10:40 - 1ц = 3 цаг 10 мин нислэг үргэлжилсэн байна.	1б. Сөүл – УБ чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.
2а. УБ – Франкфурт чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.	2б. Франкфурт – УБ чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.
3а. УБ – Токио чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.	3б. Токио – УБ чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.
4а. УБ – Алматы чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.	4б. Алматы – УБ чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.
5а. Стамбул – УБ чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.	5б. УБ – Стамбул чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.
6а. УБ – Нур Султан чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.	6б. Нур Султан – УБ чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.

ДЭЛХИЙН ЦАГИЙН БҮС IX.15.2 – II

Дараах улсуудын орших цагийн бүсийг тогтоож, аль улс нь түрүүлж шинэ жилээ тэмдэглэхийг тайлбарлаарай. <https://www.timeanddate.com/time/map/>




1. Бразил ба Ямайка

2. Англи ба Франц

3. Тайланд ба Египет

4. Шинэ Зеланд ба Мадагаскар

5. Улаанбаатар хотод өглөөний 9 : 00 цаг болж байхад дараах хотуудад орон нутгийн цагаар хэдэн цаг болж байгааг 24 цагийн системд бичиж, зураг дээр дүрсэлнэ үү.



- a. Нью – Йорк б. Дели в. Токио г. Сидней

6. Жуулчин Лондон хотоос Нью – Йорк руу (Лондонгийн цагаар) өглөөний 08: 30 минутад нисч, нислэг 6 цаг 30 минут үргэлжилсэн бол Нью – Йорк хотод буух үед
 - б. Лондонд хэдэн цаг болж байх вэ?
 - а. Нью – Йорк хотод орон нутгийн цагаар хэдэн цагт буух вэ?

.....

Дасгалын дугаар	1	2	3	4	5	6	Нийт
Өөрийн үнэлгээ							

ДЭЛХИЙН ЦАГИЙН БҮС. IX.15.1 – 15.2**Өөрийгөө сорих.**

1. Дэлхийн цагийн бүсийн зураг ашиглан ОХУ цагийн хэддүгээр бүсэд оршихыг тогтоогоорой.

2. Дэлхийн цагийн бүсийн зураг ашиглан Австрали тив цагийн хэддүгээр бүсэд оршихыг тогтоогоорой.

3. 2021 оны 9 дүгээр сарын Олон улсын нислэгийн хуваарь ашиглан асуултад хариулаарай.

Өдөр	Нисэх, буух цаг (тухайн орон нутгийн цагаар)	Чиглэл
IX/20	08:00/11:00	УБ - Сөүл
IX/20	14:30/18:40	Сөүл - УБ
IX/20	05:45/14:10	Стамбул - УБ
IX/20 – 21	17:35/02:15	УБ – Стамбул

www.gogo.mn

а. Сөүл – УБ чиглэлийн нислэг УБ хотод газардахад Сөүл хотод хэдэн цаг болж байх вэ?.....

б. УБ – Сөүл чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.

в. Стамбул – УБ чиглэлийн нислэг эхлэхэд УБ хотод хэдэн цаг болж байх вэ?

г. УБ – Стамбул чиглэлийн нислэг үргэлжилсэн хугацааг ол.

4. Дараах улсуудын аль нь шинэ жилийг эхлэн тэмдэглэх вэ? Хариултаа тодорхой тайлбарлаж бичээрэй.
Канад ба Польш

5. Лондон хотын нисэх онгоцны буудлын нислэгийн хуваарийг хүснэгтээр өгчээ.
Бүх нислэг Лондон хотоос эхлэх бол хүснэгтийн хоосон нүдийг нөхөөрэй.

Нислэгийн дугаар	Чиглэл	Явах цаг	Үргэлжлэх хугацаа	Буух цаг
01	Москва	06:45	3 цаг 10 мин	
02	Шанхай	07:00	11 цаг 30 мин	
03	Лос - Анжелос	08:50		10:20
04	Буэнос - Айрес	10:00	13 цаг	

Дасгалын дугаар	1	2	3	4	5	Нийт
Хариу						